



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/319

Булган сум

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны III/02 дугаар “Чинээлэг малчин хөтөлбөр батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлэг, үржлийн алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойд шаардагдах мэдээллийн сан бүрдүүлэх, мал аж ахуй эрхлэх арга барил, туршлагыг дэлгэрүүлэх, сурталчлах, зорилгоор аймгийн Хөдөө аж ахуйн салбарын ахмадуудын уулзалтыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, зардлыг 2 дугаар хавсралтаар баталж, шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Чинээлэг малчин хөтөлбөрөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг чанартай зохион байгуулж, ном, товхимолд шаардагдах мэдээллийг бүрдүүлж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

04 Аймгийн Засаг даргын 2023 оны
..... дүгээр сарын 26-ны өдрийн 1/20 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД МАЛ ҮРЖЛИЙН АЛБА ҮҮСЭЖ ХӨГЖСӨНИЙ ТҮҮХТ
100 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД “АХМАДАА СОНСЪЁ” УУЛЗАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

Булган сум

Зорилго: Мал эмнэлэг, үржлийн алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойн ном, товхимолд мэдээлэл нэгтгэх, мал аж ахуй эрхлэх арга барил, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлахад оршино.

Хамрах хүрээ: Ахмад мал зүйч-30, Төрийн албан хаагч мал зүйч-20, нийт 50 хүнийг хамруулна.

Хугацаа: 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр

Хийж гүйцэтгэх ажил:

1. Мал аж ахуйн салбарт олон жил орон нутагт үр бүтээлтэй ажиллаж байсан ахмад мэргэжилтнүүдийг уулзуулж, дурсамж яриа өрнүүлэх
2. Өнөөгийн байдлаар мал аж ахуйн салбарын ололт амжилт, алдаа дутагдлын талаар мэдээлэл танилцуулж, санал зөвлөмж сонсох
3. Ахмад-дунд-залуу үеийн төлөөллийг танилцуулж, хамтран ажиллах боломж олгох
4. Мал үржлийн алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойн тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийн танилцуулж санал авах
5. Мал үржлийн алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойн ном, товхимолд шаардагдах мэдээлэл ярилцлагыг авах

ОЧ дүгээр сарын 26-ны өдрийн А.З.З. дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Хүлээн авалт	50	40,000	2,000,000
2	Гарын бэлэг	30	100,000	3,000,000
	Бүгд			5,000,000